

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 04 ДҮГЭЭР ХУРАЛ**

2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 14 цаг 10 минутад эхэлж, мөн өдрийн 15 цаг 15 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын танхимд хийж, нийт 01 цаг 05 минутад хуралдав.

дд	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	“Аймгийн хошой аварга малчин”, “Аймгийн аварга малчин”, “Аймгийн аварга тариаланч”, “Аймгийн аварга саальчин шалгаруулах тодорхойлолт хэлэлцэх тухай	<p>1.“Аймгийн хошой аварга малчин” 8, “Аймгийн аварга малчин” 76, “Аймгийн аварга саалчин” 7, “Аймгийн аварга тариаланч” 13 нийт 104-ийг тус тус шалгуулж, нэрсийг хавсралтаар хавсаргах.</p> <p>2.“Аймгийн хошой аварга малчин”, “Аймгийн аварга малчин”, “Аймгийн аварга саальчин”, “Аймгийн аварга тариаланч”- дын энгэрийн тэмдэг, энгэрийн тууз, цар, дурсгалын зүйл, мөнгөн шагнал олгох / нэг аваргад 400.000 төгрөгт багтаах / саналыг дэмжиж нийт 41.600.000 /дөчин нэгэн сая зургаан зуун мянган/ төгрөгийн зардлыг захирамжаар баталж, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ч.Багдалд, захирамжийн төслийг боловсруулж танилцуулахыг . Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Г.Гончигсүрэнд</p> <p>3.Шалгарсан малчид, тариаланчид иргэдийг олон нийтэд алдаршуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, тэргүүн туршлагыг нь нэвтрүүлэх зэрэг арга хэмжээ авч ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Ганданповрон, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Г.Гончигсүрэн нарт тус тус үүрэг болгов.</p>

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР